

Монгол, Хятадын соёлын харилцааг Монгол дахь музей, соёлын өвийн жишээгээр өгүүлэх нь (1949-1962)

Доржпаламын Мандах 

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль, Улаанбаатар, Монгол Улс
psdmandakh@gmail.com

Сүндэвийн Энхнаран 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Бид “Монгол, Хятадын соёлын харилцааны онцлох үйл явдлууд” (1949-2024) хэмээх судалгаа хийж, уг судалгаанд музей, номын сан, театр, чуулга, хүмүүнлэгийн зарим онцлох үйл явдал бүхий 162 баримтыг холбогдох зураг, сонины мэдээ, архивын баримт, дурсамж, ярилцлага, эрдэмтдийн дүгнэлтээр баяжуулан он дарааллын лавлах байдлаар боловсруулалт хийсэн болно. “Эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай” хэлэлцээрийн 10 гаруй жилийн хугацаанд дахь хоёр талын соёлын харилцааны ололтууд монгол, хятадын найрамдалт, харилцан туслах харилцааны зарчмыг баримтлан шинээр төлөвшсөн дипломат харилцаа, соёлын хамтын ажиллагаа, төлөвлөгөөний дагуу хоёр улсын хооронд талуудаас зохион байгуулсан түүхэн баримтат үйл явдал, музейн салбарт хийгдсэн зарим онцлог үйл явдал, төрийн тэргүүний харилцан дурсгасан бэлэг дурсгалын үнэ цэн нь өдгөө соёлын үнэт өв болж буй талаар өгүүлэх бөгөөд тухайн үзмэр, дурсгалын зүйлээс ур хийц, материалын төрөл тус бүрээс дээжлэн авлаа. Дашрамд дурдахад бидний энэхүү судалгааны нэг баримтад холбогдох зураг бүхий нотолгоог хоёроос дөрвөн зургаар баяжуулж, нийт 700-аад зураг цуглуулж түүнээс тус өгүүлэлд хоёр улсын харилцааны “Алтан үе”-д холбогдох соёлын өвийн давтагдашгүй нандин хийц бүхий үзмэрүүдээс төлөөлөл болгож 13 зураг оруулав.

Түлхүүр үгс: дипломат бэлэг дурсгал, үзэсгэлэн солилцоо, музейн хамтын ажиллагаа, соёлын өв, захидал бичиг, соёлын харилцаа

An Examination of Mongolian–Chinese Cultural Relations through the Lens of Museums and Cultural Heritage (1949–1962)

Mandakh Dorjpalam 

School of Culture, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
 psdmandakh@gmail.com

Enkhnarar Sundev 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

Abstract: This article is based on the research project “Significant Events in Mongolian–Chinese Cultural Relations (1949–2024)”, which compiled 162 documented events related to museums, libraries, theaters, artistic ensembles, and other notable developments in the humanities. These records were enriched with photographs, newspaper reports, archival documents, memoirs, interviews, and scholarly assessments, and organized as a chronological reference source.

Focusing on the decade-long implementation of the Agreement on Economic and Cultural Cooperation, the study examines the achievements of bilateral cultural relations between Mongolia and the People’s Republic of China. It situates developments in the museum sector within the broader context of newly established diplomatic relations and cultural cooperation founded on the principles of friendship and mutual assistance. Drawing on historical documents and jointly organized cultural activities, the paper highlights significant events in the museum field, including the exchange of exhibitions, official correspondence, and diplomatic gifts. Particular attention is given to the cultural, historical, and symbolic value of commemorative objects exchanged between the two countries. The study argues that many of these objects, initially presented as diplomatic gifts, have gradually acquired the status of cultural heritage. Representative examples of artifacts made from various materials are analyzed to illustrate their craftsmanship and artistic significance. As part of the broader research project, approximately 700 photographs were collected, with two to four images serving as supporting evidence for each documented event. From this collection, fourteen photographs have been selected for this article to represent the “Golden Age” of Mongolian–Chinese cultural relations and to showcase unique heritage objects of exceptional artistic and historical value.

Keywords: *diplomatic gifts, exchange of exhibitions, museum cooperation, cultural heritage, official correspondence, Mongolia–China cultural relations.*

Оршил

Улс орнууд дипломат харилцааг найрамдал, харилцан туслалцах, нийгэм, соёл, боловсрол, эдийн засаг, бүтээн байгуулалтын хамтын ажиллагаа хөгжүүлэх, гэрээ хэлэлцэл хийх, харилцан нэгэндээ найрсаг хандах үндсэн дээр тогтоодог. Олон улсын харилцааны уламжлалд газар зүйн байршлаар бүс нутгийн болон хөрш зэргэлдээ улс орнуудын харилцааг ангилан зохион байгуулдаг байжээ. Улс орнууд

дипломат харилцаа, хамтын ажиллагааг албан захидал бичгээр харилцан мэдэгдэх, талархал илэрхийлэх, баяр хүргэх, бэлэг дурсгал солилцох зэргээр нэгэндээ найрсаг хандан хөгжүүлж эхэлдэг байна. Судлаачид Монгол Улс, БНХАУ-ын хоорондын дипломат харилцааг гурван үед хуваан авч үзсэн байна. Нэгдүгээр үе (1949-1960), хоёрдугаар үе (1962-1990), гуравдугаар үе (1990-2012)” (Алтанцэцэг 2021, 227) хэмээгээд тухайн цаг хугацаа бүрд баримталсан харилцааны бодлого, улс төрийн байр суурийг тайлбарлажээ. Үүнээс нэгдүгээр үе буюу 1949-1960 онд социалист хоёр орны харилцаа шинээр төлөвшин “найрамдалт, харилцан туслах харилцааны зарчмыг” баримталсан байдаг. Үүнийг БНХАУ-аас Монгол Улсад сууж асан Онц бөгөөд эрхт Элчин сайд Жан Дөлин хоёр улсын харилцаа аажмаар хөгжиж, арав илүү жилийн хугацаанд найрамдалт хөгжлийн цаг үеийг туулсан нь монгол, хятадын харилцааны түүхэнд “Алтан арван жил” болсон хэмээн дурссан байна. Энэ үеэс хоёр орны улс төр, худалдаа, эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, бие биеийн тусгаар тогтнолыг хүндэтгэх үндсэн дээр хөгжиж эхэлсэн байдаг.

Тэгвэл энэхүү өгүүлэлд Монгол, Хятад хоёр орны найрамдалт, харилцан туслах харилцааны зарчмыг баримтлан шинээр төлөвшсөн 1949-1962 оны соёлын хамтын ажиллагаа, 1952 оны соёлын хэлэлцээрийн 10 жилийн ойн хүрээнд ялангуяа музейн ажил, үзэсгэлэн харилцан солилцсон түүхэн жишээнд тулгуурлан судалгааны зорилтын дагуу зөвхөн музей, үзэсгэлэнгийн үйл ажиллагаа, албан уулзалтын үеэр өөрсдийн үндэстэн угсаатны уламжлал, гар урлал, урлагийн хосгүй сайн сайхныг шингээсэн бэлэг дурсгалыг харилцан солилцож байсан явдлыг дурдах юм. Ингэхдээ уг бэлэг дурсгал, үзэсгэлэнгийн цуглуулга нь Монгол Улсын музей, галерейд хөрш орны өв соёлыг хадгалсан сан хөмрөг бий болгосон талаар тэдгээр дурсгалын төлөөлөл, тайлбар, хадгалалт, бүрдэл, үнэ цэн бүхий соёлын ой санамж (Cultural Memory) болж буйг тодруулна.

Монгол, Хятадын соёлын харилцааны түүхэн дэх “Алтан үе” хэмээх тэрхүү он жилүүдийн хоорондох болсон үйл явдлаас монголын музейн салбарт БНХАУ-аас БНМАУ-д зохион байгуулсан үзэсгэлэнгийн талаарх мэдээ баримтыг архив, номын сангийн сан хөмрөг, сонин хэвлэлийн мэдээ, тухайн үйл явдлуудыг дүгнэсэн эрдэмтдийн дүгнэлт, ахмад дипломатч, судлаачдын дурсамжид үндэслэн 13 жилийн үйл ажиллагаанаас онцлох үйл явдлын баримтыг, баримтаар нотлох аргаар үзүүлж, соёлын дипломат харилцаа зөөлөн хүчний бодлогын үр дүн, ач холбогдлыг харуулах оролдлого хийснээрээ шинэлэг бөгөөд энэ төрлийн судалгааны эх хэрэглэгдэхүүн болж буйгаараа чухал ач холбогдолтой.

Монголчууд мал аж ахуй эрхэлсэн нүүдлийн, хятадууд газар тариалан эрхэлдэг суурин соёл иргэншлийн уламжлалтай ард түмэн. Эрхлэх аж ахуйн соёлоосоо үүдэн зан заншил, соёл, бичиг үсэг, шашин, сэтгэлгээ соёл иргэншлээрээ ялгаатай, эл байдал нь тухайн ард түмний гар урлал, урлагийн бүтээл, бэлэг дурсгалд хадгалагдан өвөрмөц танигдахуйц шинжийг бий болгосон нь үнэ цэнтэй юм. Энэхүү өгүүлэлд хоёр улсын дипломат харилцаа тогтоосны ойд зориулсан “Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жил” 2009 он, “Найрамдалт хамтын ажиллагааны нэгэн жаран” Бээжин 2009, “Найрамдал хамтын ажиллагаа Соёлын дурсгалууд” УБ. 2019, “Хятад Монгол

хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд зориулсан сонин мэдээллийн материалын эмхэтгэл – сонин” (1949-2019) (I, II, III, IV) боть Хөх хот 2019, “Монгол-Хятадын соёл, шинжлэх ухааны харилцаа” (1949-1965 он) Тэргүүн боть УБ. 2021, “Монгол Улсын Үндэсний төв архив, Монгол Улсын Гадаад хэргийн төв архивын баримтууд, Монгол Улсын Үндэсний музей, Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй бүтээлүүдээс ашигласан болно.

Судалгааны арга зүй

Тус эрдэм шинжилгээний өгүүлэлд судалгааны эх хэрэглэгдэхүүний түүхэн зүй, баримтын аргуудаас ашиглахдаа баримтыг соёлын болон танин мэдэхүйн үүргийн хувьд тодруулж, музейн сан хөмрөгийн бүрдүүлэлт, баримтжуулалт, үзэсгэлэн, төлөөлөл, үзмэрийн тайлан тайлбарлах, үнэ цэнжүүлэх зэрэг аргыг ашиглав.

Судалгааны үр дүн

Нэг. Найрсаг харилцааны үр дүн музей, соёлын өвд шилжсэн нь.

Үзэсгэлэн. Монгол хятадын харилцааны “Алтан үе”-д МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооноос 1952 оны 10 дугаар сарын 1-ээс 10-ны өдрийн хооронд БНХАУ байгуулагдсаны 3 жилийн ойг тохиолдуулан “Найрамдлын 10 хоног” соёлын цогц арга хэмжээг хэрэгжүүлжээ. Энэ үед монгол хятадын түүхэнд соёл урлагийн төлөөлөгчид, үзэсгэлэн солилцох, анхны алхмыг хийжээ” (Эрэнцэнсоном огноо байхгүй) (ГХТА. д. 05, хн. 185, 19). Найрамдлын 10 хоног нь найрамдалт хятадын ард түмэн өөрийн улс орны аж ахуй ба соёлын байгуулалтад олж байгаа амжилтуудтай монголын ард түмнийг танилцуулан монгол, хятадын ард түмний найрамдал, хамтын ажиллагааг цаашид бэхжүүлэх зорилготой, улс орон даяар амжилттай зохион байгуулсан байна. Эл ажлын гол цөм нь ...хот, хөдөө орон нутгийн театр, музей, улаан булан зэрэг соёлын байгууллагуудаар дамжин кино, концерт, үзэсгэлэн гаргах, мэргэжлийн урлагийнхны уулзалт зохион байгуулах арга хэлбэрээр хэрэгжсэн байв. Түүнчлэн хятадын талаас ард түмнийхээ соёл, уламжлал, тухайн цагийн хөгжлийн өнгө төрхийг олон салбараар харуулсан тусгай үзэсгэлэнг дэлгэн үзүүлж, үзэсгэлэнгийн бүхий л үзмэрүүдийг БНМАУ-ын Засгийн газарт бэлэглэсэн. Тухайн үзмэрүүдийн дийлэнхийг Монголын Үндэсний музейд, бусдыг Улаанбаатар хотын музейнүүдэд 1952 онд шилжүүлэн хадгалж хамгаалж байгаа билээ. Жишээлбэл, “Байцаа дээрх царцаа” сийлбэр тус үзэсгэлэнд дэглэгдэж байсан бөгөөд өдгөө Монголын Үндэсний музейд хадгалагдаж байна (Зураг 1).



Зураг 1. Байцаа дээрх царцаа. Зааны соёо. 30 см, 5см, 665гр.

Тус бүтээлийн хадгалалт хамгаалалт сайн, нарийн ур хийцтэй, урлаачийн нэр тодорхойгүй байна. Монголын Үндэсний музей “Зааны соёоны дээр сийлдэг сийлбэрч өнөө цагт ховорджээ. Зааны соёо нь нягтрал сайтай тул өнгө ялган будахад амаргүй. Тусгай технологийг нарийн эзэмшсэн урлаач л зааны соёоны дээр сийлбэрт өнгө ялган будаж чаддаг ажээ. Эс бөгөөс өнгө будаг нь 3-5 жилийн дотор арилдаг. Тус бүтээл өнөө хэр өнгө будгаа алдаагүй байгаа нь урлаачийн өндөр ур чадварыг илтгэн харуулж буй юм. Байцаан хуниас, давхарга бүрийг нарийн харуулсан бөгөөд дээр нь суун шим шүүсийг сорж буй царцаа, хээрийн үзэмжит цэцэгсийг уг бүтээлд тод томруун дүрслэн харуулжээ” (Монголын Үндэсний музей 2019) хэмээн тайлбарласан байна.

Өмнө дурдсан хэлэлцээр (Бээжин 1952.10.14, №96), түүний шинэчлэл тутмын хүрээнд Монгол Улсын талаас “БНМАУ-ын хөгжил” (1957.03), “БНМАУ-ын дүрслэх урлаг” (1954.05.29-06.20), “Үндэсний урлаг” (1959.07), “Монголын уран зураг” (1960) сэдэвт үзэсгэлэнг тус бүр ард иргэдэд монголчуудын хөгжил дэвшил, урлаг, гар урлалын хосгүй сайхныг танин мэдүүлэх зорилготой Бээжин хотод зохион байгуулсан байдаг. Тэгвэл хятадын талаас “Хятадын үйлдвэрийн хөгжил (1952.10.01-10), “Ардын гар урлалын эдлэл” Хятадын ард түмний гар урлалын цуглуулгаар (1959.05), “БНХАУ”, “БНХАУ-ын бүтээн байгуулалтын 10 жилийн амжилт” (1959.08), “БНХАУ-ын ололт амжилт” (1960) үзэсгэлэнг Улаанбаатар хот дахь Дүрслэх урлагийн музейд зохион байгуулж, монголын ард түмэнд үйлчилж байжээ (СУИС 2017, 209).

Эдгээр үзэсгэлэнгийн талаар цаг үе, мэдээллийн чанартай улс орны сонин, сэтгүүлд олонтоо мэдээлсэн байдаг. Үүнд:

“Монгол Хятадын найрамдлын 10 хоногийн үеэр Улаанбаатарт БНХАУ-ын аж ахуй үйлдвэрлэлийн үзэсгэлэн нээгдсэн билээ. Энэ үзэсгэлэн, үзэгч олны сонирхлыг ихэд татаж байлаа. Үзэсгэлэнд хятад орны үнэт баялгийн зүйлүүд, тэр баялгийг боловсруулж хийсэн гоц сайхан зүйлүүд тавигдсан байв. Энд шинэ хятадын машинт үйлдвэрийн амжилт, бөс торгомсгийн үйлдвэрийн үйлдэхүүн, гар урлалын талаар Хятадын ард түмний бүтээсэн гайхамшигт зүйлүүд үзэгчдэд маш их сонирхогдож байлаа. Энэ үзэсгэлэн Хятад улсын зөвхөн үйлдвэрийн хөгжлийг биш, эртний уламжлалт соёл урлагийг гайхамшигтай чадалтай харуулжээ. Энэ үзэсгэлэнд тусгалаа олсон БНХАУ-ын их амжилт ялалтууд бол монголын ард түмний баяр баясгаланг төрүүлж, манай хоёр улсын ард түмний найрамдлыг улам бэхжүүлж, манай эх орныг цэцэглүүлэн хөгжүүлэх үйлсэд биднийг улам зоригжуулж байна. Монгол, Хятадын найрамдлын 10 хоногт зориулсан энэ үзэсгэлэнг БНХАУ-ын ажилчин ангийн бэлэг болгож, манай улсад шилжүүлэхээр БНХАУ-ын Засгийн газар шийдвэрлэсэн юм. Энэ сайхан үзэсгэлэнг манай улсад зохион байгуулж улмаар түүнийг бэлэг болгож шилжүүлсэн явдалд Монголын бүх ард түмэн их баярлаж, БНХАУ-ын Ардын Төв Засгийн Газар, нөхөр Мао Цзе-Дунд ба найрамдалт Хятадын ард түмэнд талархлаа илэрхийлж байна” (Сайхан үзэсгэлэн 1952) хэмээн тухайн үеийн “Туяа” сэтгүүлд онцлон дурджээ.

Дараа жил нь буюу 1953 онд Улаанбаатар хотод “Монгол-Хятадын найрамдал” гэсэн гэрэл зургийн үзэсгэлэн, 1954 оны Найрамдлын арав хоногийг 9 дүгээр сарын 30-ны орой олон нийтийн хурал хийж эхлүүлж, хурлыг Б.Ширэндэв “БНХАУ-ын

5 жилийн ой” гэсэн илтгэлээр нээж, Хятад улсын соёлын төлөөлөгчдийн дарга нөхөр Цао Юй, элчин Хэ Ин нар баяр хүргэж үг хэлэв. ...БНХАУ-ын хөгжлийн тухай фото үзэсгэлэн Улаанбаатар хотод 2 том, 37 жижиг үзэсгэлэн тавьсан бөгөөд аймаг бүр үзэсгэлэн нэгийг байгуулсан. Мөн сумын төв, сургууль, соёлын газрууд төвлөрсөн газар бүр жижиг үзэсгэлэн гаргасан. Иймд томоохон үзэсгэлэн нийт 57-г байгуулжээ (МУУТА, ТБА. х. 276, д. 2, хн. 132, 40-43). 1955 оны 8 дугаар сарын 4-нд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гар урлалын үзэсгэлэн Улаанбаатар хотод нээгдэж, 20-оод хоногийн туршид 20 гаруй мянган хүнд сонирхуулан, бүхэл үзэсгэлэнгээ монголчуудад бэлэглэн үлдээжээ.

Энэ тухай МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 213-р тогтоолд “...Гар урлалын үзэсгэлэн Хятадын урлалын шилдэг дээжүүдээс бүрдсэн, соёлын үнэт бөгөөд сурган хүмүүжүүлэх чанартай зүйл болохыг тэмдэглээд, 1.БНХАУ-ын гар урлалын үзэсгэлэнгийн (торгомсог метрийн бараанаас бусад) бүх бүтээлүүдийг Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн мэдэлд шилжүүлсүгэй. 2.БНХАУ-ын Гар урлалын үзэсгэлэнд тавигдсан торгомсог метрийн барааг жижиглэн худалдаалах үнээр худалдаалан орлогыг Улсын төсөвт шилжүүлэхийг Худалдааны яаманд даалгасугай. 3.Гар урлалын үзэсгэлэнгийн бүтээлүүдийг нарийн тодорхой бүртгэн үнэ тогтоож шилжүүлэх комиссыг дор дурдсанаар баталсугай. ..., 4.Уг үзэсгэлэнг шилжүүлэх, хүлээн авах ажлыг 8 дугаар сарын 20-ны дотор багтаан дуусгахыг Шинжлэх Ухааны Хүрээлэнд үүрэг болгосугай. 5.Улсын Төв музейд ардын ардчилсан орнуудын урлалын бүтээлийн булан байгуулахад тус үзэсгэлэнгийн материалыг шилжүүлэн ашиглахыг Шинжлэх Ухааны Хүрээлэнд үүрэг болгосугай...” гэжээ.

1955 оны 8 дугаар сарын 4-нд Улаанбаатар хотноо нээгдсэн “БНХАУ-ын гар урлалын үзэсгэлэн”-ийн үзмэрийг “Монголын Дүрслэх урлагийн музейн үзмэр худалдан авах ба бүртгэлийн үнэ тогтоох комиссын хурлын 75-р тогтоол (1971.11.09)”-оор музейд нийт 100 гаруй бүтээл, 1968 онд Богд хааны ордон



Зураг 2. “Бэй Хай цэцэрлэг”, модон сийлбэр. Хэмжээ: Өргөн 54.3см, өндөр 34см, жин 5850гр. Хувийн дугаар: 71.75.28.¹



Зураг 3. Шувуу, Чимэглэлийн урлаг. Материал: Цаасан цоолбор, торго, цаас. Хэмжээ: Урт 11.7см, өндөр 20.3см. Хувийн дугаар: ДҮМ1971.75.119.8.²

¹ Эх сурвалж: Монголын Дүрслэх урлагийн музей

² Эх сурвалж: Монголын Дүрслэх урлагийн музей



Зураг 4. Ваар, Дархны урлал.
Материал: Цаасан шуумал, паалан.
Хэмжээ: Өндөр 27.3см, жин 437.2гр,
диаметр 10.8см.
Хувийн дугаар: 71.75.01.³



Зураг 5. Тоногтой хайрцаг, Дархны урлал.
Материал: Модон сийлбэр, хаши, гууль.
Хэмжээ: Урт 15.6см, өргөн 12.6см, өндөр
23.7см, жин 1525гр.
Хувийн дугаар: 71.75.01.⁴

музейгээс 1956 онд гарсан БНХАУ-ын “Гэр аж ахуйн урлал чимэглэл”-ийн үзэсгэлэнгээс ирүүлсэн зүйлсийг мөн бүртгэн авсан байна.

“1955 оны 9 дүгээр сарын 7-нд Улаанбаатар хотод байгуулагдсан БНХАУ-ын янзлах урлагийн үзэсгэлэн бол БНМАУ ба БНХАУ-ын ард түмний хооронд эв найрамдал, соёлын талаар хамтран ажиллах явдлыг цаашид бэхжүүлэх хэрэгт ач тусыг үзүүлж манай орны янзлах урлагийг хөгжүүлэхэд дөхөм үзүүлэх юм. Хятадын их ард түмний дээд бүтээлч уран чадварыг тодоор харуулж байгаа БНХАУ-ын янзлах урлагийн үзэсгэлэнг Улаанбаатар хотын хөдөлмөрчид гүн сонирхолтой үзэцгээсэн байна. Энэ үзэсгэлэн нь хятадын уран авьяаст ард түмний их туршлагыг хэрэглэх үндсэн дээр БНМАУ-ын янзлах урлагийн уран чадварыг дээшлүүлэх хэрэгт асар их ач холбогдолтой юм (МУҮТА, ТБА. х. 276, д. 2, хн. 132, 40-43) гэжээ.

³ Эх сурвалж: Монголын Дүрслэх урлагийн музей

⁴ Эх сурвалж: Монголын Дүрслэх урлагийн музей


БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Түүхийн ба уран сайхны талаар асар их үнэт зүйл болсон БНХАУ-ын янзлах урлагийн үзэсгэлэнгийн зүйлүүдийг БНМАУ-д бэлэг болгон шилжүүлэх явдалд ах дүү Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газарт чин сэтгэлийн талархлыг илэрхийлсүгэй.
2. Энэ үзэсгэлэнгийн үнэт зүйлүүдийг цаашид манай орны хөдөлмөрчдөд өргөнөөр танилцуулах зорилгоор уг зүйлүүдийг хайрлан хамгаалж байхыг Шинжлэх Ухааны Хүрээлэнд үүрэг болгосугай.
3. БНМАУ-ын янзлах урлагийн их туршлагыг манай амьдралд нэвтрүүлэх зорилгоор Хятадын уран чадвартны бүтээсэн уран сайхан-гар урлалын гайхамшигт зүйлүүдийг судлуулах ажил зохиохыг Аж үйлдвэрийн яам, Үйлдвэрийн хоршооллын төв зөвлөл, Дүрслэх урлагийн газарт даалгасугай (Олон улс судлалын хүрээлэн 2021, 22) гэжээ.

Ингээд гар урлалын үзэсгэлэнгийн сор болсон бүтээлээс толилуулъя.



Зураг 6. Үзэгний сав (Шөү уулын чулуу).
Үзэгний саван дээр ариун нандины бэлгэдэл
бадамцэцэг болон хос загас дүрсэлжээ.
Хэмжээ: Өргөн 16 см, өндөр 12 см,
жсин 1140 гр.⁵



Зураг 7. Тамхи шүдэнз хийх зориулалттай
сав (Шөү уулын чулуу).
Хэмжээ: Өргөн 17см, өндөр 12 см,
жсин 1150 гр.⁶

1956 онд БНМАУ, БНХАУ-ын Засгийн газрын хооронд соёлын талаар хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлтээс үзэхэд “Монгол Улсын Ардын хувьсгалын 35 жилийн ойг тохиолдуулан “Социализмыг байгуулж байгаа БНМАУ” гэдэг гэрэл зургийн үзэсгэлэн, БНХАУ-ын “Хятадын ардын цаас хайчилбар”-ын үзэсгэлэнг хүлээн авч Улаанбаатарт гаргаж, “Хятад улс” гэдэг гэрэл зургийн их хэмжээний үзэсгэлэнг мөн хүлээн авч Элдэв-Очир кино театрт (ГХТА. х. 5, хн. 185, 191-194) гаргажээ. 1957 оны 12 дугаар сарын 8-нд Улаанбаатар хотод Хятадын модон барын зургийн үзэсгэлэн нээгджээ. Харин 1958 оны 2 дугаар сарын 21-нд БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын соёлын хамтын ажиллагааны

⁵ Эх сурвалж: Монголын Үндэсний музей (Найрамдал хамтын ажиллагаа Соёлын дурсгалууд 2019)

⁶ Эх сурвалж: Монголын Үндэсний музей (Найрамдал хамтын ажиллагаа Соёлын дурсгалууд 2019)

тухай хэлэлцээрийн *Хоёрдугаар зүйлийн жс*-д Соёлын үзэсгэлэнг харилцан зохион байгуулах, *Зургаа. Үзэсгэлэн гэсэн хэсэгт*: 1.Монголын тал хятадын дүрслэх урлагийн үзэсгэлэнг 2 зураачийн хамт 7, 8-р сард хүлээн авна. 2.Хятадын тал монголын үндэсний “Хээ угалз”-ын үзэсгэлэнг 10 дугаар сард 2 зураачийн хамт хүлээж авна гэжээ. 1958 оны 9 дүгээр сарын 30-нд Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэг байгуулагдсан (ГХТА. х. 119, д.1. хн. 275) ба Хятад улсад Хятад-Монголын найрамдал нийгэмлэг мөн байгуулагдсан. Үүнээс өмнөх үеийн соёлын хамтын ажиллагаа нь “Найрамдал нөхөрлөлийн 10 хоног”-ийн ажлын хүрээнд зохиогдож байв. 1959 онд Монгол, Хятад хоёр орны соёлын төлөвлөгөөний дагуу 1959 оны 12 дугаар сарын 15-нд Монголын уран баримлын үзэсгэлэн Бээжин хотноо нээгдэж, Бээжин хотын үзэгчдийн хүртээл болов. “Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэг 1959 онд БНХАУ-ын “Аж үйлдвэрийн үзэсгэлэн” ..., Улаанбаатар хот, Өвөрхангай, Төв зэрэг аймгуудад “БНХАУ” гэсэн гэрэл зургийг үзэсгэлэн, “Сычуань мужийн гар урлалын үзэсгэлэн”, БНХАУ-ын амжилт туршлагын тухай гэрэл зургийн самбарыг Сүхбаатарын талбайд 12 удаа гаргаж, мөн “БНХАУ-ын тусламжаар манай оронд байгуулагдаж байгаа үйлдвэр, соёл, ахуйн тусламж” гэдэг фото самбар 450% хийлгэж сум, нэгдлийн төвүүдэд байгуулах ажил” (Олон улс судлалын хүрээлэн 2021, 224-226) зохиосон байдаг.

1961 оны онцлох үйл явдлын нэг бол “Монголын ардын хувьсгалын 40 жилийн ойд зориулсан “Монгол, Хятадын найрамдлын 10 хоног” арга хэмжээ БНХАУ-д зохиогджээ. Тус арга хэмжээнд оролцсон “Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэгийн төлөөлөгчдийн товч илтгэл”-д “БНМАУ” фото үзэсгэлэнг хятад хэл дээр тайлбар хийж, хөдөлмөрчдийн цуглаан дээр тайлбарлан таниулах ажил зохиогдлоо (МУҮТА, ТБА. х. 276, д. 2. хн. 282, 94-105) гэжээ.

1952 оны 10-р сарын 4-нд Бээжин хотноо баталсан “Эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай” хэлэлцээр нь энэ өдрөөсөө эхлэн 10 жилийн турш хүчин төгөлдөр бөгөөд 1962 онд Монгол-Хятадын найрамдлын 10 хоногийн ажлын төлөвлөгөө, Хятад-Монголын найрамдлын нийгэмлэгийн төлөөлөгчдөд үйлчлэх төлөвлөгөөг батлах зэрэг асуудлыг хэлэлцжээ. Төлөвлөгөөний гуравдугаарт заасны дагуу Төв талбайд “БНМАУ ба БНХАУ-ын найрамдал хамтын хамтын ажиллагаа”, БНХАУ-ын соёл урлагийн хөгжилтийг харуулсан самбар 4-ийг гаргасан байдаг (Олон улс судлалын хүрээлэн 2021, 22). Ийнхүү арав гаруй жилийн хугацаанд хоёр улсын соёлын салбар тэр дундаа музейн ажилд маш их ололт амжилт, туршлага болсон нь тухай үеийнхэнд, хойч үеийнхэндээ таниулах соёлын дурсгалт үнэ цэн бүхий “өв” буй болгосныг эл өгүүлэлд дурдсан үзэсгэлэнгүүдийн агуулга, цар хүрэнээс харж болно. Баримт бол тухайн цаг үеийн түүхийн гэрч төдийгүй соёлын болон танин мэдэхүйн чухал ач холбогдолтойг харуулдаг. Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны үр дүнд хятадын уран бүтээлчдийн уран гар, сод ухаанаар бүтсэн үнэт өвүүд өдгөө цагт Монгол Улсын музейн сан хөмрөгийн үнэт үзмэрийн дэсэд бүртгэгдэн хадгалагдан хамгаалагдаж, цаасан суурьт бүтээл (катологи)-д тусгагджээ.

Хоёр. Түүх соёлын дурсгалт зүйл. Улс орны найрсаг харилцаанд төрийн тэргүүнүүдийн албан уулзалт, харилцан солилцсон захидал, бэлэг дурсгал нь харилцааны түүх, соёлын ой санамж, хоёр улсын түүх соёлын дурсгал болон

музей, архив, соёлын өвийн газруудад хадгалагддаг билээ. БНХАУ нь БНМАУ-тай дипломат харилцаа тогтоосноо тохиолдуулан маршал Х.Чойбалсанд хос ваар 1949 онд бэлэглэсэн байдаг. Энэхүү дурсгал нь өдгөө Монгол Улсын Үндэсний музейд хадгалагдаж байна. Тус хоёр вааран дээр сүм хийд, цэцэрлэгт хүрээлэн, асар, хүн ард, навчис, цэцэг, уул ус, угалз хээг урнаар товойлгон сийлсэн байдаг. Монголын Үндэсний музей тухайн дурсгалын материал, шинж, нөхцөл байдлыг үзэхэд “*Чи маажин будагтай хос ваар. Ваарын ерөнхий төрх нь дэрвэгэр амсар, өндөр хүзүүтэй, доод суурь нь ёроол хэсгээрээ гадагшаа тэлсэн хос ваар юм. Ваарын хүзүү болон мөр нь хоорондоо тод ялгагдахаар залгаж нийлүүлсэн. Тус хос вааран дээр нэлэнхийд нь. Хэмжээ: Өндөр 46 см, дм 16 см, жин 5155 гр. Монголын Үндэсний музей*” (Хөххотын Багшийн их сургууль 2019, 110-111) гэжээ.



Зураг 8. Чи маажин будагтай хос ваар



Зураг 9. 1951 онд бэлэглэсэн
цайны хэрэглэл

Монголын ардын хувьсгалын 30 жилийн ойг тохиолдуулан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ерөнхий сайд маршал Чойбалсанд баярын мэндчилгээг БНХАУ-ын Төв Засгийн газрын Төрийн зөвлөлийн захиргааны Ерөнхий сайд Чжоу Энх-Лай (Монголын Үндэсний музей 2019, 33) хүргэж, цайны хэрэглэл дурсгасан байдаг.


“Зянши муж нь эртнээс цай болон шаазан эдлэл үйлдвэрлэлээр алдартай. Хийц, чанар сайтай шаазан үйлдвэрлэдэг тул мужийн Жэн Дэжинь хот “Шаазангийн нийслэл” хэмээн алдаршжээ. Тус хотод үйлдвэрлэсэн 17 ширхэгтэй цайны иж бүрэн хэрэглэлд “Урт насалж, удаан жарга” гэсэн ерөөлийг маршал Чойбалсанд зориулан хятадаар бичиж (Монголын

Үндэсний музей 2019, 110-111) дурсгасан бөгөөд энэхүү соёлын дурсгалт зүйл өдгөө Монголын Үндэсний музейд хадгалагдаж байна.

1952 онд БНХАУ-ын Засгийн газраас БНМАУ-ын Засгийн газарт хятадын соёлын дурсгал бэлгэдэлт “Галт шувуу, хос тогоруу”-ны хатгамалтай хаалтыг дурсгасан явдал юм.



Зураг 10. Цагаан өнгийн торгон дээр модон дээр сууж буй галт шувуу, түүнийг тойрон олон шувууд нисэлдэн буйгаар дүрсэлсэн сум модон жаазтай хаалт. Тодорхойлолт: Галт шувуу тойрон нисэж буй шувуудын зурагтай хаалт. Өргөн 82 см, өндөр 156 см.⁷



Зураг 11. Хос тогорууны хатгамалтай хаалт. Тодорхойлолт: Өргөн 82 см, өндөр 156см.⁸

Тайлбар: “Сум модон жаазыг тойруулан ланз хээ болон ургамал, амьтны дүрсийг тана чулуугаар шигтгэн урласан байна. Энэхүү торгон хатгамал дээрх галт шувуу нь домгийн амьтан бөгөөд янз бүрийн соёлтой олон үндэстэн эртнээс нааш өөрсдийн соёлд дүрслэн харуулсан байдаг хэдий ч галт шувууг бэлгэдэх шинж чанар нь төстэй. Галт шувуу нь өөрийнхөө үнс нурамнаас амилдаг тул дахин төрөлт, мөнх амьдралыг бэлгэддэг юм.” (Монголын Үндэсний музей 2019, 79).

Тайлбар: “Цагаан даавуун дээр утсаар өнгө ялган “Хос тогоруу”-г байгальтай хослуулан зохиомжилсон хатгамалтай, сум модон жаазтай, жаазыг тойруулан ланз хээ болон ургамал, амьтны дүрсийг тана чулуугаар шигтгэн урласан. Хаалтан дээр дүрслэгдсэн тогоруу шувууг хятадууд аз жаргалтай, урт удаан наслахын бэлгэ тэмдэг хэмээн үзэхээс гадна дайн тулаанд амь эрсдсэн баатар эрсийн сүнсийг нуруундаа үүрэн тэнгэрийн оронд хүргэж өгдөг хэмээн хүндэтгэн итгэдэг байна” (Монголын Үндэсний музей 2019, 81).

БНМАУ ба БНХАУ улс хооронд дипломат харилцаа тогтоосны 6 жилийн ойгоор монголын талд дараах гуулин царыг дурсгажээ.

Дотор гаднагүй битүү хээлэн чимсэн хос гуулин цар. Царны гадна талын доод ёроолыг цэнхэр өнгөөр будаж түүн дээр шар өнгөөр гурвалжин болон дугуй дүрсээр гоёжээ. Харин царны амсрыг хар болон ногоон өнгөөр будаж хөх, цагаан, улаан өнгийн дугуй хээгээр чимэглэжээ.

⁷ Эх сурвалж: Монголын Үндэсний музей 2019.

⁸ Эх сурвалж: Монголын Үндэсний музей 2019.



*Зураг 12. Гуулин цар.
Үзмэрийн тодорхойлолт:
Өндөр нь 11 см, диаметр 37см.⁹*

1955 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр тухайн үеийн БНМАУ, ЗСБНХУ, БНХАУ-ын хооронд төмөр замын шууд харилцаа байгуулах тухай гурван улсыг холбосон өргөн царигтай төмөр замын шугам нээгдсэн нь гурван улсын найрамдлын түүхэн тэмдэглэлт онцгой үйл явдал болсон юм. Тухайн үед энэ түүхэн үйл явдлыг гэрчилсэн уран бүтээлч, гар урчууд ур ухаан, оюун билгээ уралдуулан олон сайхан бүтээл туурвин үлдээжээ. Өдгөө хүртэл урлаг соёл, уран бүтээл, уран зохиол, оюун бүтээлийн агуулга, сэдэв, төрх, хэв шинжид шилжсээр найрамдалт харилцааны соёлын ой санамж (Cultural Memory) болжээ.

Тайлбар: “Монгол, Хятад, Орос гурван улсыг өргөн царигтай төмөр замаар холбох төслийн төлөвлөгөөг хэлэлцэж буй байдлыг өнгийн торгон утсаар битүү хатгах аргаар урлан харуулсан түүхэн сэдэвт бүтээл. Уран хатгамалч Б.Цэрмаа Монгол, Хятад, Орос гурван улсыг өргөн царигтай төмөр замаар холбох төслийн түүхэн хэлэлцээрийг зохиомжлон, битүү хатгаасаар 1955 онд урласан нь одоо Монголын Үндэсний музейд хадгалагдаж байна.

Хэлэлцүүлэг

Монгол, Хятадын соёлын харилцааг эрдэмтэн судлаачид олон талаас нь судалж байна. Тухайлбал, талуудын соёлын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан үзэсгэлэн солилцоо нь өдгөө монгол улсын музей сан хөмрөгт соёлын ой санамж үнэт өвийг бий болгон судалгааны эргэлтэд орж, хойч үеийнхэнд таниулах ажил амжилттай хийгдэж буй нь дээрх бүтээлүүдээс харагдаж байгаа бөгөөд хоёр улсын Элчин сайдын яам онцгой чухал үүрэгтэй оролцож, хоёр орны соёлын хамтын ажиллагаа “Зөөлөн хүч”-ний бодлогыг амжилттай хэрэгжүүлж ирсний тод жишээ юм.

⁹ Эх сурвалж: Монголын Үндэсний музей 2019.

Дүгнэлт

1949-1962 оны Монгол, Хятадын соёлын харилцааг музей, соёлын өвийн жишээгээр авч үзсэн тус судалгаанд хоёр улсын дипломат харилцааны “найрамдалт, харилцан туслах” зарчим музей үзэсгэлэнгийн агуулга, хэлбэрт шилжин хөрш зэргэлдээ орнуудын хамтын ой санамжийг бүтээсэн байна. Ялангуяа соёлын дипломат ажиллагаа нь улс төр, эдийн засгийн харилцааг дэмжих зөөлөн хүчний үр дүнтэй хэрэгсэл мөн болохыг музейн салбарын эл үйл явдлууд нотолж байна. Тухайн үеийн үзэсгэлэн солилцоо, гар урлал, дүрслэх урлагийн бүтээлүүд, түүхэн бэлэг дурсгал зэрэг соёлын хамтын ажиллагааны үр дүн өнөөгийн Монгол Улсын музей, архив, соёлын өвийн сан хөмрөгт хосгүй үнэт өв болон хадгалдагдаж байна. Энэ нь соёлын дипломат харилцааны тогтвортой, урт хугацааны үр дүн болох тул түр зуурын сурталчилгааны шинжтэй биш юм.

Өдгөө музейн сан хөмрөг бүрдүүлж буй эдгээр үзмэр, цуглуулга, бэлэг дурсгал нь тухайн цаг үеийн улс төрийн харилцааг илэрхийлэхээс гадна хоёр ард түмний соёлын үнэт зүйл, гоо зүй, гар урлалын уламжлалыг харилцан таниулдаг болжээ. Үүний үр дүнд Монгол Улсын музейн сан хөмрөгт БНХАУ-ын түүх, соёлыг төлөөлөх сан хөмрөг бүрдсэн байна.

Иймд 1949-1962 оны Монгол, Хятадын соёлын харилцааг музей, соёлын өвийн жишээгээр авч үзэх нь хоёр улсын харилцааны “Алтан үе”-ийн мөн чанарыг ойлгоход чухал ач холбогдолтой төдийгүй, орчин үеийн соёлын дипломат бодлого, музейн хамтын ажиллагаанд түүхэн туршлага, сургамж өгөхүйц судалгааны үнэ цэнтэй юм.

Энэхүү өгүүлэлд Монгол, Хятадын соёлын харилцааг монгол дахь музей, соёлын өвийн жишээгээр өгүүлэхдээ судалгаанд авсан нийт 162 баримтаас Монголын Үндэсний музей, Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж буй үнэт үзмэрээс торгон хатгамал, шаазан эдлэл, модон сийлбэр, зааны ясан соёон дээрх сийлбэр, чулуун сийлбэр, цаасан цоолбор зэрэг материалаар бэлгэдэлт амьтан шувууд, гэр ахйун хэрэгсэл, соёлын бараа зэргийг ур чадварын өндөр түвшинд үүрдийн бүтээл хийсэн нь тод харагдана.

Уг судалгааны үргэлжлэл Монгол Улсаас Хятад улсад гаргасан үзэсгэлэн, монголын нэрт зураач, уран бүтээлчдийн тухай өгүүлэх болно.

Ашигласан материалын жагсаалт

Алтантөгс, Н. 2022. “БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр ба Монгол, Хятадын соёлын харилцаа, хамтын ажиллагаа: 1950-аад он.” *БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр 70 жил*. Улаанбаатар.

Базардорж, Д., Алтантөгс, Н. 2022. “БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр байгуулагдсан нь: Үйл явц, ач холбогдол.” *БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр 70 жил*. Улаанбаатар.

Гао Шүмао (Ред.). 2017. *Хятад, Монголын дурсамжууд*. Бээжин.

Монголын Үндэсний музей. 2019. *Найрамдал хамтын ажиллагаа: Соёлын дурсгалууд*. Улаанбаатар.

Олон улс судлалын хүрээлэн. 2021. *Монгол-Хятадын соёл, шинжлэх ухааны харилцаа. (1949-1965 он). Тэргүүн боть*. Улаанбаатар.

“Сайхан үзэсгэлэн.” Туяа. *Нийгэм улс төр, утга зохиол- урлагийн 2 сар тутмын сэтгүүл*, 1952/11-12 дугаар сар №6 (15).

Соёл урлагийн их сургууль. 2017. *Соёл урлагийн тайлбар толь Музей*. Ред. Сонинтогос Э. Улаанбаатар.

Хөххотын Багшийн их сургууль. 2019. *Хятад, Монгол хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд зориулсан сонин мэдээллийн материалын эмхэтгэл-сонин. (I-IV)*. Хөххот.

Архивын материал:

ГХТА. *Хятад улс*. х. 5, хн. 185, 191-194.

ГХТА. *Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэг байгуулагдсан*. х. 119, д.1. хн. 275.

МУҮТА, ТБА. *Монгол, Хятадын найрамдлын 10 хоног*. х. 276, д. 2. хн. 282, 94-105.

МУҮТА, ТБА. “*Монгол-Хятадын найрамдал*” гэсэн гэрэл зургийн үзэсгэлэн. х. 276, д. 2, хн. 132, 40-43.

Эрэнцэнсоном. *Монгол Хятадын хоорондын соёлын харилцааны (1952-1956) лавлах*. ГХТА. д. 05, хн. 185, 19.